

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Д.Сарангэрэл, М.Оюунчимэг нарын 13 гишүүнээс 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд Хүүхдийн эрхийн тухай конвенцын үзэл санаа, зарчимд нийцүүлэн зарчим, хамрах хүрээг нэмэгдүүлэх, хүүхдийн хамгаалагдах эрхийн хүрээнд хүүхэд хамгааллын кейс үйлчилгээний талаарх нэр томъёог олон улсын жишигт нийцүүлэн шинээр нэмж тодорхойлох, орон нутгийн түвшинд /сум, хороонд/ хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх, орон тооны нийгмийн ажилтан ажиллуулах, тэднийг удирдлага, бодлого, зохицуулалт, арга зүйгээр хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн хуваарилалт, зарцуулалтыг тодорхой болгох, цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, цахим үйлчилгээ үзүүлэгч иргэдийн үүрэг хариуцлага, хүүхдийг цахим орчинд хамгаалах салбар дундын бүтцийг сайжруулах, байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн бодлогодоо хүүхэд хамгааллын бодлогыг тусган хэрэгжүүлдэг, хяналт тавьдаг олон нийтийн, орон тооны бус эцэг эхийн зөвлөл байгуулж, хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийллийг бууруулах сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, байгууллагадаа хүүхэд ээлтэй орон зай бүрдүүлэх замаар албан хаагчдынхаа ажил, амьдралын тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг тус тус тусган боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар хүүхэд хамгааллын тогтолцоо бэхжиж, төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг бүх түвшинд тодорхойлогдож, хүүхэд хамгааллын үйлчилгээ төрөлжиж, чанар, хүртээмж дээшлэх, хүүхэд хамгаалалд зориулсан төсвийн үр ашиг, өгөөж сайжирна гэж төсөл санаачлагчид үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, С.Одонтуяа нар хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сард өргөн мэдүүлэх хуулийн төсөлтэй нэгтгээд хэлэлцэх нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа хүүхдийг хүчирхийлэлд өртсөний дараа биш хүчирхийлэлд өртөхөөс өмнө арга хэмжээ авдаг байхаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг 2016 оноос хойш Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд хүүхэд хамгааллын төсвийг 1.0 тэрбумаас 13.0 тэрбум хүртэл үе шаттай нэмэгдүүлсэн, иймд төсвийн хуваарилалтыг оновчтой зарцуулах, хүүхэд хамгааллын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар санал хэлсэн болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



М.ОЮУНЧИМЭГ